



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдаах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 48,970,500.00 (дөчин найман сая есөн зуун далан мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн өрөнхий захирал Э.Галбадрахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдаах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001323

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн  
*ХСН* дугаар тогтоолын хавсралт



Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах  
тээврийн хэрэгслийн жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал                | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Гүйлт, км (мянга) | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)                             | Худалдах доод үнэ (төгрөг)               |
|-----|--|-----------------------------------|-------------------|--|--|
| 1   | Хьюндэй таксон, 71-99 УНЦ, арал№ KMHJT81BCBU327096 | 2011/2011                         | 88196             | 33,500,000.00  | 3,500,000.00                             |
| 2   | Тоёота гранвия, 28-98 УНН, арал№ VCH3800001834     | 2003/2003                         | 306506            | 15,470,500.00  | 2,500,000.00                             |
|     | <b>Нийт дүн</b>                                    |                                   |                   | <b>48,970,500.00 /дөчин найман сая есөн зуун далан мянга таван зуун/</b> | <b>6,000,000.00 /зургаан сая төгрөг/</b> |